

## ЗҮҮН ХОЙТ АЗИ: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

Ц.Баатар\*  
Б.Сэржав\*\*

ЗХА-ийн орнуудын Бүс нутгийн судалгааны институт бүхэн улс орныхоо хөгжлийн чиг хандлага, явц байдлыг бүсийн орнуудын эдийн засагтай харьцуулан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгдөг уламжлал нэгэнт тогтжээ. Манайд энэ талын дагнасан судалгаа өнөө хэр бараг байхгүй. Түүнд анхаарал тавьж, ач холбогдол өгдөг газар ч алга. Бид энэ удаа Японы Ниигатагийн ЗХА-ийн Эдийн Засгийн Судалгааны Хүрээлэн /ERINA/-ээс эрхлэн 2003 оны зургаадугаар сард гаргасан судалгааны материал, түүнчлэн өөрсдийн хир хэмжээнд олдсон судалгааны болон статистикийн мэдээ, материал зэрэгт тулгуурлан түүвэр судалгаа хийж, бүс нутгийн орнуудын /БНАСАУ-аас бусад/ 2002 оны эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг шинжлэн авч үзэх оролдлого хийлээ. Ингэхдээ бид тухайн орнуудын ДНБ, инфляцийн түвшин, гадаад худалдааны баланс гэсэн 3 үзүүлэлтийг гол шалгуур үзүүлэлт болгон авч үзэв. Цаашдаа бид энэхүү судалгааны ажлаа үргэлжлүүлж, үр дүнг тогтмол нийтэлж байх зорилт тавьж байна.

### Эдийн засгийн өсөлт

2002 оны хувьд бүс нутгийн орнуудын эдийн засаг ерөнхийдөө эерэг хандлагатай байлаа. Эдийн засагт нөлөөлөхүйц санхүүгийн болон үйлдвэрлэл, худалдааны дуулиан тарьсан хэрэг явдал ч гарсангүй. Харин ч орон бүрт үйлдвэр, худалдаагаа өргөжүүлэн хөгжүүлэх таатай боломж олгосон он жил болж өнгөрлөө.

2002 онд Хятадын эдийн засгийн өсөлт 8 хувьд хүрэв. Энэ нь өмнөх оны 7.3%-иас давж, бүс нутгийн орнуудын дунд хамгийн тогтвортой өсөлттэй орны нэг хэвээр байлаа. ОХУ-ын хувьд эдийн засгийн өсөлт 4.3% болж өмнөх оны 5.0%-иас буурсан үзүүлэлт гарлаа. Гэсэн хэдий ч энэ орны хувьд 1999 оноос хойш 4 жил дараалан эерэг өсөлт үргэлжлэв. БНСУ-ын хувьд валют санхүүгийн хямралын уршгаар 1998 онд эдийн засгийн сөрөг үзүүлэлттэй байсан хэдий ч түүнээс хойш эдийн засаг эрс өсөлттэй явж ирлээ. 2001 онд 3.1%, 2002 онд 6.3%-

\*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

\*\*Б.Сэржав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

ийн өсөлттэй байв. Япон улсын хувьд 1997-1999 онд буюу Азийн санхүүгийн хямралын үед эдийн засгийн хөгжлийн эрч нь нэлээд саарсан. 1999-2000 онд эдийн засгийн өсөлт 3%-д хүрсэнээ 2000 оноос хойш буурсаар 2002 онд нэг орчим хувьтай байв. Манай улсын эдийн засаг 3.9%-иар өслөө. Цаг уурын тааламжгүй нөхцөл, экспортын гол гол бүтээгдэхүүний үнийн уналт зэрэг сөрөг хүчин зүйл нөлөөлсөн хэдий ч эдийн засгийн өсөлт өмнөх оны үзүүлэлтээс өндөр байна. Энэ онд ч нааштай ахиц өөрчлөлт гарахаар байна.

ЗХА-ийн орнуудын хувьд 2003 он ч эерэг үзүүлэлтэй байх болно гэж шинжээчид үзэж байна. Энэ нь ч урьдчилсэн гүйцэтгэлээс тодорхой харагдаж байгаа билээ.

### **Инфляцийн түвшин**

Бүс нутгийн орон бүрт инфляцийн түвшин харилцан адилгүй байна. Энэ үзүүлэлтээр Өмнөд Солонгос бүсийн орнууд дотроо хэвийн инфляцтай, Япон, Хятад дефляцтай, Орос, Монголд инфляц үргэлжилсэн хэвээр байв.

Хятад улсад бараа бүтээгдэхүүний үнэ үйлдвэрлэхэд гарсан зардлаасаа 0.7 хувиар буурч, дэлхий дахинаа анхаарал татаж буй дефляцийн шинж тэмдэг нэгэнт эхлээд байна. Үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний үнэ үйлдвэрлэхэд гарсан зардлаа нөхөж чадахгүй доош нь унахыг дефляц гэдэг. Энэ нь нэг ёсондоо тухайн орны эдийн засгийг удирдан залж буй хөдөлгүүрийн механизмд гэмтэл согог гарлаа гэсэн үг. Үүний учир шалтгааныг богино хугацаанд илрүүлж газар авхуулалгүй засахгүй бол ужгирч даамжирвал улс орны эдийн засагт ноцтой сөрөг үр дагавар авч ирдэг. Япон улсын хувьд яг ийм байдалд ороод 4 дэх жилийнхээ нүүр үзэж байна. 1999 онд дефляц 0,3 хувь, 2000, 2001 онд 0,7 хувь, 2002 онд 0,9 хувь болсон нь Японы эдийн засгийн өсөлтөд нөлөөлж буй гол сөрөг хүчин зүйлийн нэг болоод байна. ОХУ-ын хувьд инфляци /бараа бүтээгдэхүүний үнэ өсч мөнгөний ханш буурах үзэгдэл/ үргэлжилж, 2002 онд 15.1%-ийн инфляцтай байлаа. 1998 онд ОХУ-д болсон санхүүгийн хямралын үед инфляц 84,4%-тай байсан бол түүнээс хойш тасралтгүй буурсаар ирсэн хэдий ч, ерөнхийдөө инфляцийн түвшин өндөр хэвээр байна.

Монголд ч мөн адил инфляци үргэлжилж, 2002 онд өмнөх оны 8.0%-иас давж 9.8%-ийн үзүүлэлттэй байв.

Өмнөд Солонгосын хувьд Азийн валют санхүүгийн хямралын уршгаар импортын үнэ өсч, 1998 онд үнийн өсөлт 7.5%-тай байв.

Түүнээс хойш үнийн өсөлт тогтвортой буурч, 2002 онд 2.7% байлаа. ЗХА-ийн орнуудын инфляцийн түвшин 1995-2002 онд хэрхэн хэлбэлзэж ирснийг дараах хүснэгтээс харна уу.

### ЗХА-ийн орнуудын инфляцийн түвшин

/хувиар/

Орнууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Хятад	17.1	8.3	2.8	-0.8	-1.4	0.4	0.7	-0.7
Орос	131.3	21.8	11.0	84.4	36.5	20.2	18.6	15.1
Монгол	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	9.8
Өмнөд Солонгос	4.5	4.9	4.4	7.5	0.8	2.3	4.1	2.7
Япон	0.1	0.1	1.8	0.6	-0.3	-0.7	-0.7	-0.9

Эх сурвалж: ERINA REPORT, June, 2003Vol.52, 80-86

### Гадаад худалдааны баланс

ЗХА-ийн орнуудын гадаад худалдааны баланс Монголоос бусад орны хувьд ашигтай байна.

Хятад улсад экспорт огцом өсч 1997, 1998 онд гадаад худалдааны ашиг 40 тэрбум ам. доллараас давсан үзүүлэлттэй байв. 1999 оноос импортын хэмжээг нэмэгдүүлснээр гадаад худалдааны ашиг багасч, 2001 онд 22.6 тэрбум ам. доллар болсон хэдий ч 2002 онд энэ үзүүлэлт дахин 30.4 тэрбум ам. доллар болж өслөө. Япон улсын хувьд Азийн хямралын үед ч түүнээс хойш ч гадаад худалдааны баланс тогтмол өндөр ашигтай байна. Тухайлбал 1995 онд 131,7 тэрбум ам доллар, 1996 онд 83,5 тэрбум ам. доллар, 1997 онд 101,6 тэрбум ам. доллар, 1998 онд 122,3 тэрбум ам. доллар, 1999 онд 123,3 тэрбум ам. доллар, 2000 онд 116,7 тэрбум ам. доллар, 2001 онд 70,2 тэрбум ам. доллар, 2002 онд 93,5 тэрбум ам. доллар байв. ОХУ-д 1999 оноос хойш экспорт өсч, импорт бууран гадаад худалдааны балансын ашиг тогтвортой өсч ирэв. 2002 оны хувьд өмнөх оноос буурсан ч, 46.4 тэрбум ам. долларын хэмжээнд байна. Өмнөд Солонгос валютын хямралаас хойш гадаад худалдааны ашигтай баланстай байна. 2002 онд өмнөх оныхоос илүү ашигтай байж 14.18 тэрбум ам. долларт хүрчээ.

ОХУ ДХБ-аас тавьж буй шаардлага, нөхцөл болзолыг хэрэгжүүлж чадахгүй байгаагаас энэ байгууллагад гишүүнээр элсэх явдал хойшлогдсоор өдий хүрлээ.

Манай улсын хувьд гадаад худалдааны баланс 158 сая долларын алдагдалтай байна. 1998 оноос хойш 7 жил дараалан гадаад худалдааны баланс алдагдалтай явж ирлээ. Экспортын хувь хэмжээг

нэмэгдүүлэх талаар төр засгаас системтэй арга хэмжээ авахгүй бол эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна. Бүс нутгийн орнуудын эдийн засгийн гол үзүүлэлт, түүнд нөлөөлж буй зэрэг сөрөг хүчин зүйлүүдийн талаар товч авч үзлээ.

ЗХА-ийн гадаад худалдааны балансын 1995-2002 оны үзүүлэлтийг дараах хүснэгтээс үзнэ үү.

### ЗХА-ийн орнуудын гадаад худалдааны баланс

/сая. ам. долл./

Орнууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Хятад	16.700	12.220	40.420	43.570	29.230	24.100	22.600	30.400
Орос	20.310	22.471	17.025	16.869	36.130	60.700	49.429	46.400
Монгол	58	-27	-17	-158	-155	-79	-116	-158
Өмнөд Солонгос	-4.444	-14.965	-3.179	41.627	28.371	16.872	13.492	14.180
Япон	131.790	83.560	101.600	122.390	123.320	116.720	70.210	93.574

Дээрхи эдийн засгийн суурь үзүүлэлтээс харахад бүсийн орнуудын нийгэм эдийн засгийн хөгжил тийм ч муугүй нааштай өөдрөг хандлага ажиглагдаж байна. Гэхдээ дээрхи үзүүлэлтүүд тухайн орнуудын хөгжлийн хандлагыг төгс илэрхийлэх үзүүлэлт биш гэдэг нь тодорхой.

Одоо бид ЗХА-ийн бүс нутагт тухайлан хамрагддаг ОХУ, Хятадын муж, хязгаар нутгийн эдийн засгийн өсөлт, хөгжлийн түвшинг улс орныхоо эдийн засаг хөгжлийн түвшинтэй харьцуулан авч үзье.

### Хятад улс /Зүүн хойт 3 муж/

Хятад улсын хувьд 2002 онд санхүүгийн идэвхтэй бодлого барьж, мөнгөний ханшийг тогтвортой байдалд байлгасны үр дүнд дотоодын эрэлт хэрэгцээ тасралтгүй нэмэгдэж, эдийн засаг нь засгийн газрын зорилт болгон дэвшүүлсэн 7.0%-иас давж 8.0%-ийн өсөлттэй байлаа. Ялангуяа Зүүн хойт 3 мужийн эдийн засгийн өсөлт улсын дундач үзүүлэлтээс нэлээд дээгүүр байсан нь ихээхэн сонирхол татаж байна. Эдгээр мужуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбар эрчимтэй хөгжиж байгаатай үүнийг холбон тайлбарлаж болох юм.

2002 онд эдийн засгийн өсөлт Ляонин мужид 10.2%, Гирын мужид 9.5%, Хар мөрөн мужид 10.3% байсан нь улсын дундаж үзүүлэлт 8.0%-иас нэлээд дээгүүр байна. Зүүн хойт 3 мужийн эдийн засгийн үзүүлэлт 1997 оноос хойш 6 жил дараалан улсын дундаж өсөлтөөс дээгүүр үзүүлэлттэй байгаа юм. Үйлдвэрлэлийн өсөлт /үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ/-ийг салбар тус бүрээр авч үзсэн ч дээрх 3 муж

бүх талаар улсын дундаж өсөлтөөс дээгүүр, ялангуяа хүнсний үйлдвэрлэл, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний жижиглэн худалдааны өсөлт тэргүүн байрыг эзэлж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтийн хэмжээ өндөр байв.

Ляонин мужийн эдийн засгийн өсөлт 10,2%-д хүрсэн нь 1995 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийн хэмжээ 8.0%, 9.9%, 11.1%-иар тус тус өслөө. Дээрхи үзүүлэлтээс харахад үйлчилгээний салбарын үйлдвэрлэл илүү хурдацтай өсчээ. Мөн металлурги, нефть, химийн үйлдвэрлэл, электроник, мэдээлэл холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр голлосон аж үйлдвэрийн салбарын өсөлт ч сайн байлаа. Гадаад худалдааны өсөлтийн хэмжээ Ляонин мужийн хувьд Зүүн хойт 3 муж дотроо доогуур байсан хэдий ч 2002 оны сүүлийн хагаст эрчимтэй өсчээ. Сүүлийн хагас жилд экспортын хэмжээ эрчимтэй өсөхөд нөлөөсөн гол зүйл нь машин техник, цахилгаан бараа, өндөр технологийн бүтээгдэхүүний экспорт сайн байсан, мөн гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн экспорт нэмэгдсэнд оршино. Гол экспортлогч орнууд Америк, АСЕАН, ОХУ-д гаргаж буй экспорт тус бүр 20-30% өссөн онцлогтой он боллоо. Мөн Гонконг, Өмнөд Солонгос, Япон зэрэг Зүүн хойд Азийн орнууд болон Өмнөд Америкийн орнуудад гаргасан экспорт ч өссөн байна. Нөгөө талаар импортын хэмжээ өмнөх оныхоос 6.6%-иар нэмэгджээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт амжилттай хэрэгжиж, хөрөнгө оруулалтын хэмжээ 25.8% өссөн нь нийт улсын дундажаас өндөр байна.

Гирин мужийн эдийн засгийн өсөлт 9.5% хүрсэн нь шинэчлэлт нээлттэй бодлогыг хэрэгжүүлснээс хойш хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Гирин мужийн хүнсний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь 2002 онд нийт улсын дундажаас дээгүүр байв. Түүгээр ч үл барам Зүүн хойт 3 муж дотроо ч тэргүүлж байна. Гирин мужийн 2002 оны хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 22 сая 150 мянган тонн /өмнөх оныхоос 13.4% өссөн/, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ түүхэнд хамгийн их 64 тэрбум 440 сая юанд /өмнөх оныхоос 20.3% өссөн/ хүрэв. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гадаад хөрөнгө оруулалттай үйлдвэрийн эзлэх хувь дээшилж 21.8% боллоо. Гадаад худалдаанд экспорт өмнөх оныхтай харьцуулахад 21.0%, импорт 11.1%-иар өслөө. Экспортын бараанд газар тариалангийн бүтээгдэхүүн, ялангуяа эрдэнэ шишийн

экспорт үлэмж нэмэгдэж, экспортын хэмжээ нь 6 сая тн, мөнгөн дүнгээр 600 сая доллар боллоо. Гэвч шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оныхоос дөнгөж 5.9% өссөн нь улсын дундажтай харьцуулахад ихээхэн доогуур, Зүүн хойт 3 муж дотроо ч сүүлчийн байранд оржээ. Гадаадын хөрөнгийг амжилттай оруулах нь Гирин мужийн цаашдын эдийн засгийн хөгжлийн түлхүүр гэж хэлэхэд болох биз ээ.

Хар мөрөн мужийн эдийн засгийн өсөлт 10.3%-д хүрч, сүүлийн жилүүдэд тогтвортой өсөлт үргэлжилж байна. 2002 онд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ огцом өсч, гадаад худалдаа өргөжсөн нь Хар мөрөн мужийн эдийн засгийн гол онцлог боллоо. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд цагаан будааны үйлдвэрлэл өмнөх оныхтой харьцуулахад 9.4%-иар буурсан хэдий ч, эрдэнэ шишийн хэмжээ 30.6%-иар өслөө. Мөн сүүлийн жилүүдэд ОХУ-д экспортлож буй үр тарианы хэмжээ өмнөх оныхоос 50.5%-иар нэмэгдлээ. Гадаад худалдааны байдлыг авч үзвэл Хар мөрөн муж нь улсаас авч хэрэгжүүлж буй экспортыг урамшуулан дэмжих бодлогоос ч давуутайгаар өөрийн муждаа экспортыг урамшуулах бодлогыг хэрэгжүүлж, гадаад худалдааны нийт хэмжээг 4 тэрбум 350 сая ам. долларт /өмнөх оныхоос 28.5%-иар өссөн/ хүргэж чадлаа. Үүнд импортын хэмжээ 2 тэрбум 360 сая ам. доллар /өмнөх оныхоос 33.2% өссөн/ экспортын хэмжээ 1 тэрбум 990 сая ам. доллар /23.3% өссөн/ болжээ. Экспортын бараанд цахилгаан бараа гэх мэт аж үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний хэмжээ үлэмж өсч, нийт экспортын дотор 76.5%-ийг эзэлж байна. Мөн гадаад худалдааны түншийн хувьд ОХУ-тай хийсэн худалдаа түүхэндээ хамгийн өндөр үзүүлэлтэд хүрч, 29.7%-иар нэмэгдэн, тус мужийн гадаад худалдааны 53.6%-ийг эзэллээ.

2002 онд БНХАУ-ын Зүүн хойт 3 мужийн эдийн засаг амжилттай хөгжиж ирсэн боловч ажилгүйдлийн асуудал нэлээд хурцаар тавигдаж байна. 2002 оны эцсээр зөвхөн хотуудад хийсэн бүртгэлийн байдлаар ажилгүйдлийн хэмжээгээр Гирин муж улсын дундажаас доогуур түвшинд байсан боловч Ляонин, Хар мөрөн мужид оны эцсийн байдлаар зөвхөн хотуудад 740 мянга, 388 мянган хүн ажилгүй байна. Ажилгүйдлийн хувь дээрхи 2 мужид 6.7%, 4.9% байгаа нь улсын дундажаас /4.0%/ ихээхэн дээгүүр үзүүлэлт болов. Мөн байнгын бус ажилгүйдлийн байдлыг авч үзвэл Ляонин мужид 2002 онд 770 мянган хүн болж, нийт улсын хэмжээнд бүртгэгдсэн байнгын бус ажилгүй нийт 4 сая 100 мянган хүний 20%-ийг эзэлж байна. Хар мөрөн мужид ч гэсэн Ляонин мужийн нэгэн адил түр ажилгүйчүүдийн тоо олон, нийт улсын





Эрчим хүчний үйлдвэрлэл	100 сая квт	16.54 0	11.7 %	N.A.	N.A.	N.A.	N.A.	N.A.	N.A.
Барилга	100 сая юань	7.407	8.0%	827	8.7%	179	11.6%	253	8.5%
Хөрөнгө оруулалт		43.20 2	16.1 %	1.60 5	13.0%	805	18.4%	1.10 8	11.5 %
Тээвэр, шуудан холбоо		5.518	7.7%	N.A.	N.A.	139	7.7%	265	10.0 %
Ачаа тээвэр	100 сая тн/км	49.38 7	3.8%	1.91 4	2.8%	616	0.2%	976	0.1%
Төмөр замын тээвэр		15.47 7	6.2%	971	0.0%	409	▲1.1%	748	0.2%
Авто замын тээвэр		6.704	5.9%	222	2.7%	93	8.1%	168	0.9%
Усан зам		26.48 1	1.9%	661	8.7%	0.3	▲14.8 %	16	▲7.4 %
Далайн тээвэр		52	17.9 %	1.4	26.4%	N.A.	N.A.	0.3	- 2.5%
Зорчигч тээвэр	100 сая хүн/км	13.96 6	6.2%	586	4.1%	232	5.4%	400	1.0%
Төмөр зам		4.969	4.2%	340	4.2%	133	4.5%	163	0.1%
Авто зам		7.643	6.0%	174	4.0%	84	5.9%	222	1.3%
Усан зам			▲5.6 %	8.6	2.1%	0.1	▲23.7 %	0.1	23.0 %
Агаарын тээвэр		1.269	16.2 %	63	4.3%	N.A.	N.A.	15	10.5 %
Боомтоор ачаа тээсэн хэмжээ	10000 тн	27	11.6 %	16.5 65	11.6%	N.A.	N.A.	N.A.	N.A.
Худалдаа	100 сая юань	8	17.0 %	5.69 1	20.20 %	N.A.	N.A.	N.A.	N.A.
Жижиглэнгийн худалдаа		40.91 1	8.8%	2.25 8	11.0%	1.00 8	10.9%	1.32 0	10.1 %
Үнийн өсөлт		-	▲0.8 %	-	▲1.1%	-	▲0.5%	-	▲0.7 %
Хотод		-	▲1.0 %	-	▲1.1%	-	▲0.8%	-	▲0.7 %
Тосгонд		-	▲0.4 %	-	▲1.3%	-	▲0.3%	-	▲0.5 %
Хүнс		-	▲0.6 %	-	▲2.6%	-	▲1.2%	-	▲0.6 %
Тээвэр, холбоо		-	▲1.9 %	-	▲1.2%	-	▲3.6%	-	▲0.5 %
Зугаа цэнгээ соёлын бараа		-	0.6%	-	2.6%	-	0.8%	-	▲0.6 %
Орон сууцны зардал		-	0.6%	-	▲0.5%	-	3.4%	-	1.7%
Үйлчилгээний хөлс		-	▲0.1 %	-	N.A.	-	2.8%	-	▲0.6 %
Гадаад худалдааны нийт дун	100 сая долл	6.208	21.8 %	217. 4	9.8%	37.1	15.6%	43.5	28.5 %
Экспорт		3.256	22.3 %	123. 7	12.4%	17.7	21.0%	19.9	23.3 %
Импорт		2.952	21.2 %	93.7	6.6%	19.4	11.1%	23.6	33.2 %
Гадаадын хөрөнгө оруулалт		N.A.	N.A.	42.6	18.7%	5.5	5.7%	12.4	7.4%
Шууд хөрөнгө оруулалт		828	19.6 %	39.2	25.8%	3.2	5.9%	9.5	9.8%
Мөнгөн хадгаламж	100 сая юань	183.3 88	18.1 %	7.60 0	17.7%	3.03 2	15.6%	4.23 7	13.2 %
Зээллэг		139.8 03	15.4 %	6.24 7	11.2%	3.20 7	6.7%	3.62 4	7.7%
Хүн ам	10000 хүн	1280. 453	-	4.20 3	-	2.69 9	-	3.81 3	-
Хүн амын өсөлт	%	6.45	-	1.34	-	3.19	-	2.54	-
Хотууд дахь ажилгүйдлийн %	%	4.0	-	-	-	3.6	-	4.9	-



Тайлбар ► уналтыг харуулсан тэмдэг.

Эх сурвалж: Хятад улсын статистикийн газрын материал /2002/

### **ОХУ /Алс Дорнод/**

2002 онд ОХУ-ын уул уурхайн аж үйлдвэрлэл 3.7%-иар өссөн хэдий ч Алс Дорнодод энэ үзүүлэлт 0.9%-иар бага өсөлттэй байлаа. Гэвч муж тойрог тус бүрээр авч үзвэл Чукоткын автономит тойрог /20.5%/ , Еврейн автономит тойрог /11.0%/ зэрэг эрчимтэй өсөлттэй бүс нутаг ч байна. 2001 онд зөвхөн Приморийн хязгаарт л гэхэд үйлдвэрлэл 15 хувиар буурсан бол 2002 онд Камчатка /16%/ , Сахалин муж /12.5%/ -уудад уул уурхайн үйлдвэрлэл буурсан байна.

Алс Дорнодод жижиглэн худалдаалсан бараа бүтээгдэхүүний өсөлтийн хувь ОХУ-ын дундажаас өндөр, Саха-гийн БНУ, Сахалин муж, Чукоткын автономит тойрогт улсын хэмжээний өсөлтөөс 2 дахин их өсөлт гарсан байна. Хэрэглээний үнийн өсөлтийн хэмжээ нь 33%-тай байсан Чукоткын автономит тойргоос бусад муж нутагт, ОХУ-ын үзүүлэлттэй адил хэмжээнд байв. Ажилгүйчүүдийн тоо 15%-иар буурч, ялангуяа Еврейн автономит район, Хабаровск муж болон Магадан мужид 30%-иас илүү хувиар буурч, ОХУ-ын үзүүлэлттэй харьцуулахад ихээхэн нааштай үзүүлэлт гарлаа.

### **Хабаровск муж, Приморийн хязгаарын нийгэм, эдийн засгийн байдал**

ОХУ-ын Алс Дорнодын эдийн засаг, улс төр, соёлын төвийн байр суурийн төлөө өрсөлдөж буй Хабаровск муж болон Приморийн хязгаарыг харьцуулан авч үзье. Юуны өмнө Хабаровск мужид 2001 онд уул уурхайн үйлдвэрлэл 12% өссөн бол 2002 онд дөнгөж 6%-иар өсч, өсөлтийн хувь буурсан юм. Тэгвэл Приморийн хязгаарын уул уурхайн үйлдвэрлэл Хабаровскыг бодвол эсрэгээр 2001 онд 15.2% буурсан бол 2002 онд 1.2% өссөн үзүүлэлт гарч, огцом уналтыг зогсоож чадсан байна.

Үйлдвэрлэлийн салбар тус бүрээр авч үзвэл, Хабаровск мужид түлш, нефть боловсруулалт, нүүрс олборлолт, ган машин техникийн үйлдвэрлэл зэрэг үйлдвэрлэлийн гол салбарт өсөлттэй байсан хэдий ч, 2002 онд өсөлтийн хэмжээ буурсан, түүнчлэн үйлдвэрлэл уналттай гарсан салбарууд ч олон байна. Өсөлтөөс уналт руу орсон салбар гэвэл, хөнгөн үйлдвэрлэл /2001 онд 1.9%, 2002 онд 7.8%/ , загас агналтыг оролцуулан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл /2001 онд

2.6%, 2002 онд 6.3%/ уналтанд орсон сөрөг үзүүлэлт гарсан юм. Хабаровсктай харьцуулахад Приморийн хязгаарт 2001 онд уналттай байсан олон салбарт өсөлт гарсан байна. Тухайлбал хими, нефть химийн аж үйлдвэр 160% /2001 онд 1.9%/, техник тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, металлургийн салбар 15.6% /2001 онд 27%/, барилгын материалын үйлдвэрлэл 12% /2001 онд 7.9%/ -иар тус тус өсчээ. Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтаар Хабаровск муж нийт дүнгээр ч /17 тэрбум 800 сая рубль/, өсөлтийн хувиар ч /19%/, Приморийн хязгаараас /12 тэрбум 300 сая, 9%/ давж гарчээ.

2002 онд гадаад худалдааны хэмжээ Приморийн хязгаарт 1 тэрбум 790 сая ам. доллар болж, 0.6% -иар өсчээ. Тэгвэл Хабаровск мужид 1 тэрбум 630 сая ам. доллар болж 27% -иар буурсан байна. Энэ нь Комсомолск Амурын нисэх онгоцны үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлох эрх Москвагийн үйлдвэрт шилжиж, бүс нутгийн экспортод тооцохгүй болсонтой холбоотой юм. Техник тоног төхөөрөмжөөс бусад бүтээгдэхүүний экспорт 25% -иар өсчээ. Экспорт, импортын бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд дээрх 2 муж ерөнхийдөө адилхан бөгөөд экспортоор далайн бүтээгдэхүүн, мод, модон материал, металлыг голлон гаргаж, импортоор техник, төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн болон бусад түүхий эд, өдөр тутмын хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг голлон оруулж байна. Гадаад худалдааны балансын хувьд 2 муж хоёулаа балансын ашигтай байна. 2002 онд экспорт өсч, импорт буурснаар балансын ашиг улам өсчээ.

Хабаровск болон Приморийн хязгаарын хүн ам 2002 онд хоёул 0.7% буурч, 2 мужийн хүн ам тус бүр 1 сая 476 мянга, 2 сая 109 мянга болжээ. Алс Дорноддоо хамгийн олон хүн амтай Приморийн хязгаар нь жижиглэн худалдаалсан бараа бүтээгдэхүүний үнийн дүнгээр ч 1-р байранд байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2002 онд 14.3% -иар өсч, 42 тэрбум 300 сая рубльд хүрчээ. Хабаровск муж нь жижиглэн худалдаалсан бараа бүтээгдэхүүний үнийн дүн 33 тэрбум рубль /11.5% өссөн/-д хүрсэн бөгөөд мужийн хүн амын амьдралын түвшин дээгүүр, тухайлбал мужийн хүн ам тутамд ногдох бодит орлого сард 4330 рубль байгаа нь Приморийн хязгаарын 3074 рублиэс дээгүүр байна.

Сүүлийн жилүүдэд Хабаровск мужийн эдийн засаг харьцангуй тогтвортой өсч ирсэн бол Приморийн хязгаарын эдийн засаг тогтвортой байж чадсангүй. Цаашид тогтвортой өсөлтийг хадгалахын тулд эдийн засгийн гол гол салбаруудыг тогтвортой хөгжүүлэхэд улсын болон хувийн секторын хамтын ажиллагааг бэхжүүлэх, экспорт,

валютын хэмжээг өсгөх, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг өргөн хэрэглээний салбарын үйлдвэрлэлийг мужийн дотоодод эрчимтэй хөгжүүлж бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, нийгмийн салбарын хөрөнгө оруулалтад засгийн газрын үүргийг нэмэгдүүлэх зэрэг бодлогын чанартай асуудал тулгараад байгаа ажээ.

**Оросын Алс Дорнодын бүс нутгийн нийгэм,  
эдийн засгийн байдал**

	Уул уурхайн үйлдвэрлэл /2001 онтой харьцуулахад/	Жижиглэн худалдаа нийт дүн	Үнийн өсөлт	Ажилгүйдлийн түвшин	Бүс нутгийн уул уурхайн нийт үйлдвэрлэл улс, бүс нутгийн дундажтай харьцуулсан хувь
Саха БНУ	1.7	22.8	12.1	9.0	1.24 (28.78)
Примор	1.2	14.3	13.6	1.2	0.71 (16.58)
Хабаровск	6.0	11.5	17.6	32.1	1.09 (25.17)
Амур	0.2	3.8	12.4	8.0	0.23 (5.26)
Камчатка	16.0	2.0	14.1	22.6	0.29 (6.78)
Магадан	6.9	7.2	12.3	30.0	0.23 (5.39)
Сахалин	12.5	18.3	17.6	23.9	0.44 (10.29)
Еврейн автономит	11.0	18.0	19.9	34.1	0.03 (0.60)
Чукотка	20.5	19.3	32.7	1.3	0.05 (1.16)
Алс Дорнод	0.9	13.4	15.2	15.1	4.31 (100.00)
ОХУ	3.7	9.1	15.1	10.9	100.00

Эх сурвалж: ERINA REPORT, June, 2003Vol.52, 80-86

**Япон улс**

Японы “хөөж гүйцэн” хөгжих нийгэм-эдийн засгийн болон хүнд сурталт загвар нь нэгэнт гараагаа эхэлсэн глобалчлалын үйл явцтай нийцэхгүй байгааг тус улсад арван жил үргэлжилсэн эдийн засгийн хямрал харуулж байна. 50-70-аад онд эдийн засгийн гайхалтай өсөлтийн “Япон ид шидийг” харуулж байсан эдийн засгийн хөгжлийн үндэсний загварын тэрхүү өвөрмөц шинжүүд глобалчлалын эриний шинэ эдийн засагт таарч тохирох юм бараг үгүй болжээ. Энд өмчийн хамссан бүтэц ч, Японы менежмент ч, банкуудын хяналтанд байдаг санхүүгийн зах зээл ч, “насан туршид хөлслөгддөг” тогтолцоо бүхий хөдөлмөрийн зах зээл ч, төр болон пүүсүүдийн харилцаанд төрөөс гүйцэтгэдэг зохицуулагч үүрэг ч цөм багтаж байна. Эдүгээ Япон улс дэлхий нийтийн зах зээл, дэлхий дахины өрсөлдөөний сүрлэг хүчинд эдийн засгаа нээж өгөх шинэчлэлтийн дөнгөж эхэнд л явна. Гэвч япончууд энэхүү ширүүн урсгалд улс орноо алдахыг огтхон ч хүсэхгүй байна. Шинэ нөхцөлд улс орны дотоодод болон олон улсын тавцан

дээр төрөөс ямар үүрэг гүйцэтгэх талаар амаргүй эрэл хайгуул хийж байна.

Ялангуяа эдийн засаг эргэн сайжрахад гол хүчин зүйл нь нэгэнт гүнзгийрээд байгаа дефляцийг зогсоох явдал хэмээн хүлээн зөвшөөрөөд байна. Японд сүүлийн хэдэн жилд бүтээгдэхүүн, үнэт цаас, газрын үнэ унах үзэгдэл үргэлжилж үүнээс болж, ажилгүйдэл нэмэгдэх, цалин буурах, бүтээгдэхүүний чанарт нөлөөлөх явдал газар авсаар байна. Дефляцийг ужигруулж байгаа шалтгааныг 1. гадаадын зах зээлээс хямд бараа ихээр орж ирж байгаа явдал. 2. Ялангуяа сүүлийн хэдэн жилд технологийн өрсөлдөөн улам хүчтэй болж байгаа. 3. Мөнгөний эргэлт удааширч санхүүгийн зах зээлийн механизм хэвийн ажиллахад саад болж байгаа зэрэгтэй холбон үзэж ирлээ. Тухайлан санхүүгийн зах зээлийн хэвийн бус ажилгаанаас болж мөнгө үйлдвэрлэгчид нийлүүлэгдэхгүй, өөрөөр хэлбэл, банкинд мөнгө хуримтлагдаж, жинхэнэ хэрэгцээтэй байгаа жижиг дунд үйлдвэрүүдэд мөнгөн зээллэг олдохгүйд хүрээд байгаа юм. Койзүмигийн засгийн газар байгуулагдаж, бүтцийн шинэчлэлтийг эхлээд 3 жил гаруй өнгөрч байгаа хэдий ч, энэ хугацаанд мөнгөний эргэлтийг сайжруулахад олигтой нөлөөлж чадахгүй байгаа юм.

Одоогоор Японд 5 сая гаруй үйлдвэр байгаагийн, 97% нь жижиг дунд үйлдвэр юм. Японы эдийн засаг жижиг дунд үйлдвэргүйгээр оршин тогтнож чадахгүй гэж үздэг. Тэгээд ч засгийн газрын бүтцийн шинэчлэлийн бодлогод жижиг дунд үйлдвэрийг чухалчлан үзэж 2002 онд гэхэд л 1 сая 700 мянган үйлдвэрт тусгай хөнгөлөлт үзүүлээд байна.

2002 онд Японд хөдөлмөрийн зах зээлийн байдал эерэг хандлагад орж чадсангүй, ажилгүйдэл урьдын хэвээр их байлаа. 2002 оны эцэс гэхэд Японд ажилгүйдэл 5.5%, өөрөөр хэлбэл 20 хүний нэг нь ажилгүй байгаа үзүүлэлт гарчээ. Ялангуяа залуучуудын дунд ажилгүйдэл маш их, 25 хүртэлх насны залуучуудын 9.9% нь ажилгүй байгаа нь нийгмийн сэтгэл зовоосон асуудал болоод байна.

Засгийн газрын бүтцийн шинэчлэлийн бодлогыг дефляцийг зогсооход эрчимтэй чиглүүлэх, аж үйлдвэрт шинэчлэлт хийхдээ тухайлбал Японы зах зээлд бүтээгдэхүүнээ ихээр нийлүүлж буй Хятадын үйлдвэрүүдийн нөлөөг бодолцон, Хятадад үйлдвэрлэж чадахгүй байгаа, зөвхөн Японд үйлдвэрлэх боломжтой салбарыг бодож олох, өөрөөр хэлбэл аж үйлдвэрийн шинэ хэлбэрийг хайж олох, ингэснээр гадны эдийн засгийн нөлөөллөөс ангижирч болох тухай ч эрэл хайгуул

явагдаж байна. Үүнийг хэрэгжүүлэх боломж байгаа тухай ч ярьж байна. тухайлбал Японд жилдээ 1 сая 200 мянган хүн шинээр үйлдвэрийн газар байгуулахад оролцож, хэрэг дээрээ 180 мянган аж үйлдвэр үүсч байгуулагдаж байдаг. Тэгвэл Америкийн эдийн засаг Японыхоос 2 дахин том, Америкт жилдээ 720 мянган үйлдвэр шинээр байгуулагддаг. Тиймээс Японд дор хаяж 480 мянган үйлдвэр бий болох боломж бий. Зөвхөн ийм орчинг л бүтцийн шинэчлэлийн үр дүнд бий болгох хэрэгтэй байна гэсэн дуу хоолой хүчтэй болж байна.

1999 оны долдугаар сард сайд нарын танхим Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн зөвлөлөөс бэлтгэсэн “Бодит нийгэм-эдийн засаг ба эдийн засгийг сэргээх бодлого” гэсэн арван жилийн төлөвлөгөөг баталсан юм.

Уг төлөвлөгөөнд Япон улсын 90-ээд оны эдийн засгийн уналт нь хөгжлийн мөчлөгийн ээлжит тааламжгүй үе шат байсан төдий биш, адил тэнцүү үр дүнд үндэслэсэн аж ахуйн системийн сүйрэл, аж үйлдвэржилтийн эрин үеэс адил тэнцүү бололцоог эрхэм болгодог эрдэм мэдлэгийн эрин үед орох түүхэн шилжилтийн эхлэл болсныг шууд дурдсан байдаг.

Өөрөөр хэлбэл, дээрх баримт бичигт дайнаас хойш мөрдөгдөж байсан нийгэм-эдийн засгийн тэгшитгэх үзэл суртлын хамгийн гол нэг тулгуур өөрчлөгдсөнийг тунхаглан зарлаж, хувь хүмүүсийн бүтээлч санаачлага, эрсдэлтэй холбоо бүхий урамшууллын механизм нэвтрүүлэхийг угтан тодорхойлсон юм.

Дээрх төлөвлөгөөнд бас өндөр технологи шаардсан салбаруудад ажиллуулахаар мэргэжил мэдлэг сайтай боловсон хүчнийг Японд цагаачлуулах замд учирч байгаа саад тотгорыг багасгахаар заасан билээ. Өрсөлдөх асуудлыг сайжруулах асуудал эрхэлсэн комисс ажлаар хангах бодлого явуулахдаа, бүтээмж багатай салбарууд дахь байгаа ажлын орон тоог хадгалаад байх биш, харин цаашид өсөж дэгжих бололцоотой аж ахуйн өндөр бүтээмж бүхий салбаруудад хүний нөөц ихээр урсан ирэх боломжийг дэмжиж урамшуулах аргад шилжихийг зөвлөмж болгосон байна. Түүнчлэн орон тоог хадгалж байгаагийнх нь төлөө ажил олгогчдод татаас өгдөг одоогийн практикаас татгалзах, үүний оронд ажилгүйчүүдийг мэдээллийн болон шинэ эдийн засгийн бусад салбарт ажиллуулах зорилгоор давтан сургахтай холбогдсон зардлын нэг хэсгийг төлөх баталгааг төрд ногдуулахыг бас санал болгожээ.

2000 эхээр Засгийн газрын дэргэдэх Think-tank (Оюуны төв)-ийн эрдэмтэд “Дотоод хязгаар: бие хүний бололцоог өргөжүүлэх ба шинэ мянганд төрийн удирдлагыг сайжруулах нь” гэсэн баримт бичиг нийтлүүлсэн юм. Тэд Японы өнөөгийн нийгмийн дүр төрхийг тодорхойлж байгаа зүйлүүдийг, тухайлбал эвлэрэнгүй үзэл, нэгдмэл саналаар шийдвэр гаргах хандлага, тогтоосон хэм хэмжээг ямагт мухар сохроор даган мөрдөж, бие хүн төрөөс бүрэн хараат байдаг явдал, түшмэл зан, нийгэм-эдийн засгийн зүсэн зүйлийн байгууллага гэх мэт улс орны нэгдмэл байдлын баталгаа хэмээн олон зууны турш сурталчлан магтаж байсан тэр зүйлүүдийг эрс хурцаар шүүмжилсэн байна.

Зохиогчид Японд, ялангуяа англи хэлний тал дээр “даяарчлалын мэдлэг” хангалтгүй байгаа явдалд ихэд харамсаж байгаагаа илэрхийлжээ. Ингэхдээ тэд англи хэл, компьютер техник, интернетийн ноу-хау эзэмших зэргийг “глобалчлалын орчинд тэсч гарах түлхүүр” хэмээн тодорхойлсон байна. Япон улс глобалчлалын эрин үед бусадтай алхаа нийлүүлэн хөгжин цэцэглэнэ гэвэл “хөшиж царцсан” нийгэмдээ өөрчлөлт хийх хэрэгтэй гэж тэд уриалаад, тухайлбал “бие хүний бололцоог эрс өргөжүүлэх”, эрс зоримог алхам хийж буй хүмүүст аль болох дээд зэргийн дэмжлэг үзүүлэх, “өөрийн хүчинд тулгуурлахын сацуу өрсөлдөгчдөө хүндэтгэх үзэл санааг төлөвшүүлэхийг” санал болгосон байна.

Илтгэлд өгүүлснээр бол, Японд байнга аж төрж байгаа хүн амын бүрэлдэхүүнд гадаадынхан дөнгөж 1,2 хувийг эзэлж, байгаа нь аж үйлдвэр өндөр хөгжсөн бусад орнуудынхаас хавьгүй бага байна. Мөн Японд хөгширөлт ирээдүйд сэтгэл зовиноуйц хэмжээгээр ихсэж, олон салбарт өөртөө ажиллуулах япон хүн олж чадахгүй байна. Улс оронд ашиг тустай байж болох гадаадын хүмүүст Японд байнга оршин суухад нь дэмжлэг үзүүлэхийг илтгэлд санал болгожээ.

Одоо Японд шинэ маягийн менежерүүд төрөн гарч байна. Тэд глобалчлалын үеийн зах зээлийн шаардлагыг мэдэрч, орон тоог цөөрүүлэн, ашиггүй үйлдвэрүүдийг хаан, зардлыг багасгаж, өрсөлдөх чадварыг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн болон гадаадын корпорацуудтай нэгдэн хүч хавсарч байна.

Японы улс төрийн бодлоготнууд, дунд шатны удирдлага болон бизнесменүүдийг нэгтгэж байсан “төмөр гурвалжин”-д ч ан цав үүслээ. Хуучирсан хэм хэмжээгээ халж, орчин үетэй нийцсэн эдийн засгийн болон улс төрийн бодлого явуул хэмээсэн Өрнөдийнхний шахалтад дарамтлуулж буй Японы Засгийн газарт тус улсын шинэ үеийн

бизнесменүүдээс тавьж байгаа шаардлага ч хүчтэй нөлөөлөх боллоо. Азийн хөршүүд нь ч бүс нутгийн хөгжил дэвшлийн хурдасгуурын үүрэг гүйцэтгэгчийн байр сууринд Япон улсыг буцааж аваачихуйц зоримог өөрчлөлтүүд хийхийг Токиогоос тэсч ядан хүлээж байна.

### **БНСУ**

#### Макро эдийн засгийн хөгжлийн хандлага ирээдүйн төлөв

2002 оны эдийн засгийн бодит өсөлт нь 6.3% болж өмнөх оны 3.1%-иас дахин өссөн байна. Жилийн ажилгүйдлийн хувь ч өмнөх онд 3.7% байснаа 3.1% болж буурчээ. Мөн инфляцийн түвшин хэрэглээний үнээр өмнөх онд 4.1% байсан бол өнгөрсөн онд 2.7% болж буурлаа. Макро эдийн засгийн үзүүлэлтээр 2002 онд БНСУ-ын эдийн засаг хэвийн сайн байлаа.

Төв банк, Корей банк болон Засгийн газрын судалгааны байгууллага-Өмнөд Солонгосын Хөгжлийн Хүрээлэн /KDI/-ээс энэ оны 4-р сард, 2003 оны эдийн засгийн төлөв байдалд тус тусгаа судалгаа хийжээ. Хоёр байгууллагын судалгааны дүн ихэд ойролцоо гарсан бөгөөд судалгаагаар БНСУ-ын эдийн засгийн өсөлт удаашрах хандлага ажиглагджээ. Энэ оны эдийн засгийн өсөлтийг Корей банк 4.1%, KDI 4.2% гэж тооцоолсон бөгөөд аль аль нь өнгөрсөн 12-р сард 5.7%, 5.3% гэж тооцоолж байснаас доогуур үзүүлэлттэй байхаар тооцжээ.

Хоёр байгууллага хоёулаа тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, хэрэглээ зэрэг дотоодын эрэлт хэрэгцээ зогсонги байхаар төсөөлж техник тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын өсөлтийг Корей банк 3.3%, KDI 3.4%, иргэдийн хэрэглээний өсөлтийг Корей банк 2.3%, KDI 2.1% байх тооцоо гаргажээ. Мөн өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг Корей банк 3.9%, KDI 3.8% байх, аль аль нь энэ оныхоос өсөх төлөвтэй байхаар тооцоолжээ. Ажилгүйдлийн түвшиний тооцоог зөвхөн Хөгжлийн хүрээлэн гаргасан бөгөөд 3.4% хэмээн энэ жилийн түвшингээс дээгүүр байхаар судалгаа гарчээ.

Дотоодын эрэлт хэрэгцээний ерөнхий хандлагын тухайд дээрх хоёр байгууллага хоёул оны эхний хагаст ихээхэн уналттай байснаа сүүлчийн хагаст тодорхой хэмжээгээр сэргэлт ажиглагдах төлөв байгааг заажээ. Түүнчлэн тус хоёр байгууллага хоёул Умард Солонгосын цөмийн асуудлын хурцадмал байдал зэрэг Солонгосын эргэн тойрон дахь олон улсын байдал сөргөөр нөлөөлж жилийн сүүлийн хагасын дотоодын эрэлт хэрэгцээ сэргэх нөхцлийг хаах, түүгээр ч зогсохгүй жилийн турш эдийн засаг бүр хүндрэх аюул байгааг цохон тэмдэглэжээ.



Тиймээс энэ жилийн эдийн засгийн өсөлт 3%-ийн түвшинд хүртэл доошлох ч магадлал байгааг харгалзан эрсдлээс зайлсхийх бодлогын менежмент шаардлагатай байгааг судлаачид тэмдэглэж байна.

Түүнчлэн өнөөгийн байдлаар Өмнөд Солонгосын эдийн засгийн ужиг өвчин гэж хэлж болохоор хэмжээнд байгаа хөдөлмөрийн маргааны асуудал нь бараа гүйлгээний системд нөлөөлж эхлээд байна. Жолооч нарын цалин хөлсөө нэмэгдүүлэх шаарлага тавьж ажил хаялт зарласан явдал гэр ахуйн цахилгаан бараа, автомашины дугуй зэрэг экспортын барааны чингэлгэн тээвэр болон цемент зэрэг дотоодын тээвэрт ихээхэн хохирол учраад байна. Цаашид ийм байдал даамжирвал өнөөгийн Өмнөд Солонгосын засгийн газраас дэвшүүлж буй Зүүн хойд Азийн ачаа тээврийн сүлжээний бүтцийн тухай санаачлага биелэхгүйд хүрч болзошгүй. Тэрчлэн гадаадын үйлдвэр худалдааны түншүүд нь Өмнөд Солонгосын ачаа тээврийн системд итгэх итгэл буурч, Азийн санхүүгийн хямралаас хойш Өмнөд Солонгосын эдийн засгийн сэргэлтийн хүчин зүйл болж ирсэн дотоодын шууд хөрөнгө оруулалтын хандлагад ч ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болно. Энэ мэт таагүй хандлага эдийн засгийн бодит өсөлтөд ч сөргөөр нөлөөлж болзошгүйг дээрх судалгааны үр дүн харуулжээ. 1998 оноос хойшхи БНСУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн ерөнхий дүр зургийг дараах хүснэгтээс үзнэ үү.

### БНСУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөв байдал

үзүүлэлт	1998	1999	2000	2001	2002
ДНБ (%)	6.7	10.9	9.3	3.1	6.3
Хэрэглээний зардал (%)	9.8	9.4	6.7	4.2	6.2
Үл хөдлөх хөрөнгө (%)	21.2	3.7	11.4	1.8	4.8
Аж үйлдвэрийн нийт бүт.(%)	6.6	25.0	17.1	0.9	7.3
Ажилгүйдэл (%)	6.8	6.3	4.1	3.7	3.1
Гадаад худалдааны баланс /сая ам. доллар/	41.627	28.371	16.872	13.492	14.180
Экспорт	132.313	143.686	172.268	150.439	162.471
Импорт	93.282	119.752	160.481	141.098	152.126
Ханш /вон ам.доллар тай харьцах /	1.399	1.190	1.131	1.291	1.251
Үйлдвэрлэлийн үнэ (%)	12.2	2.1	2.0	1.9	1.6
Хэрэглээний үнэ (%)	7.5	0.8	2.3	4.1	2.7
Акцийн үзүүлэлт /1980. 01. 04-ийг 100 гэж үзлээ/	4.6	807	734	573	757

### **БНАСАУ**

Энэ улсын улс төрийн нөхцөл байдал бүсийн орнуудын эдийн засгийн интеграцлалд ихээхэн учир холбогдолтой. Тийм учраас Хойт Солонгос бүс нутгийн орнууд төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан хэвээр байна. Ерөнхийд нь авч үзвэл Хойт Солонгост эдийн засгийн хүндрэл, өлсгөлөн үргэлжилсээр байна. 2002 онд Солонгос хоорондын харилцаанд ч нааштай өөрчлөлт гарсангүй. Бүс нутгийн интеграцийн хөгжилд чөдөр тушаа болсон хэвээр байна.

2002 оны гүйцэтгэлээр улсын төсвийн орлого 0.5%-иар нэмэгдэн, төсвийн зарлага 0.2% болж буурчээ. 2003 оны төсвийн тухайд орлого өмнөх оныхоос 13.6%-иар нэмэгдэх, зарлага мөн 14.4%-иар нэмэгдэхээр төсөвт тусгажээ. 2002 оны эдийн засгийн байдлын тухайд аж үйлдвэрлэл 2001 оныхоос 112%-иар нэмэгдэж, улсын төсвийн зарлагын 22.7% нь улс ардын аж ахуйн салбаруудын хөрөнгө оруулалтад зориулсан бол, 14.9%-ийг батлан хамгаалах зардалд зарцуулжээ. Хөрөнгө оруулалт илүүтэйгээр оруулсан салбарт эрчим хүчний аж үйлдвэр, нүүрсний аж үйлдвэр, металлург төмөр замын тээврийн салбарууд орж байна.

БНАСАУ 2002 оны 7-р сараас эдийн засгийг өөрчлөн сайжруулах арга хэмжээ авч эхэлсэн билээ. Энэ шинэ бодлогын талаар “эд барааны үнэ болон амьдралын зардлыг тооцох тусгай тогтолцоог хэрэгжүүлэх зэргээр хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд зохицуулж аж ахуйн удирдлагыг сайжруулж, ард түмний аж амьдралыг дээшлүүлэхийн төлөө шинэ арга хэмжээг хэрэгжүүлснээр өөрийн онцлог бүхий социалист системийн давуу талыг бүрэн харуулж болох өргөн зам нээгдлээ” хэмээн Ардын Дээд Хурлын 10 дахь удаагийн 6 дахь чуулганаас өөдрөгөөр үнэлсэн байна.

2003 оны эдийн засгийн төлөв байдлын тухайд гэвэл улсын төсвийн орлого өмнөх оныхоос 13.6%-иар өсөхөөр төлөвлөсөн атал, улсын үйлдвэрийн газруудын ашиг орлого 5%, хөдөө аж ахуйгаас орох орлого 3.3%, газрын түрээсний орлого 3.7%-иар тус тус өсөхөөр тусгагдсан байна. Тиймээс нөөц мөнгө хөрөнгийг үр ашигтайгаар дайчлан ашиглахын тулд Солонгосын дайнаас хойш анх удаагаа бонд гаргахаар тогтож, өнгөрсөн 5-р сарын 1-нээс худалдаж эхлээд байна. Улсын төсвийн зарлагын тухайд батлан хамгаалах салбарын аж үйлдвэрийг тэргүүн зэрэгт хөгжүүлэх, хөнгөн аж үйлдвэр, газар тариаланг давуутай хөгжүүлэх зарчимд тулгуурлан, улсын төсвийн 15.4%-ийг батлан хамгаалах зардалд зарцуулахаар заажээ. Мөн түлш,

эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхийн тулд цахилгаан эрчим хүчний салбарт оруулах хөрөнгө оруулалтыг өмнөх оныхоос 12.8%, нүүрсний аж үйлдвэрийн салбарт 30%, газар тариалангийн салбарт 21.3%, хөнгөн аж үйлдвэрийн салбарт 12.4%-иар өсгөхөөр төсөвт тусгажээ.

Хоёр Солонгосын сайд нарын түвшингийн ээлжит уулзалтууд болж байгаа хэдий ч төдийлэн үр дүнд хүрээгүй байна. Гэсэн хэдий ч Өмнөд Солонгосын бизнесийн бүлгийнхэний шууд хөрөнгө оруулалт жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Хойд Солонгост улс төрийн тогтолцооноос гадна жил бүр тохиолдож буй ган гачиг, үер усны аюулаас болж 6 сая орчим хүн өлсгөлөнгийн байдалтай байгаа тухай саяхан НҮБ-ээс мэдээлсэн билээ. Энэ байдлыг өөрчлөх цорын ганц арга бол “улс төрийн өнөөгийн тогтолцоог хүч хэрэглэх замаар халах явдал” гэж гадаадад дүрвэн гарсан Ким Чен Ир-ийн зөвлөх саяхан дэлхий нийтэд мэдэгдлээ. Хойд Солонгосыг тойрсон хурцадмал байдал ийнхүү үргэлжилсэн хэвээр байна. Магад ч үгүй Солонгосын хойгт богино хугацаанд энхийг тогтоох үйлс тэр эрхэмийн өгүүлснээр болохыг ч үгүйсгэх аргагүй юм.

### **Монгол**

#### Эдийн засгийн өсөлт ба гадаад худалдаа, санхүүгийн алдагдал

2002 оны өвөл, өмнөх хэдэн өвлийг болвол төдийлөн хүндрэлтэй биш өнгөрлөө. Гадаад худалдааны алдагдал, санхүүгийн алдагдал үргэлжилсээр байгаа хэдий ч, өсөлтийн хандлага ажиглагдаж эхллээ. 2002 онд ДНБ 231.3 сая төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 3.9%-иар өссөн дүн гарлаа. Уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт 2003 оны 1-р улиралд ч хэвээрээ үргэлжилж, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 3.1%-иар өсчээ. Ялангуяа аж үйлдвэрийн салбар 7.7%-иар өссөн байхад уул уурхай, эрчим хүчний салбарын өсөлт дөнгөж 0.5%, 1.2%-тай байв. 2002 онд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хэмжээ, 1991 оноос хойшхи хамгийн бага 1.6%-тай байсан байна. Гэвч гадаад худалдаа болон санхүүгийн байдал өмнөхөөс дордож ирлээ. Гадаад худалдааны алдагдал 2002 онд 170 сая ам доллар болж өмнөх онтой харьцуулахад 45.3% нэмэгдсэн байна. 2003 онд ч энэ байдал үргэлжлэх төлөвтэй байна. Манай улсын хувьд дотоодод техник тоног төхөөрөмжийн үйлдвэр хөгжөөгүй учраас уул уурхай, барилга, тээвэр холбоо зэрэг салбарт үйлдвэрлэл өргөжиж, хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Гэтэл тэрхүү хөрөнгө оруулалтад хамаарагдах бараа материалыг импортыг өсгөхөд

хүргэдэг. Нөгөө талаар экспортын гол нэр төрөлд орох ноолуур, зэсийн олон улсын зах зээлийн байдал энэ хугацаанд сайн биш байсантай уялдан экспортын хэмжээ импорттой харьцуулахад өсөлт багатай байна. Цаашид экспортыг дэмжсэн бодлого тууштай явуулж, хувийн секторыг бүх талаар хөхүүлэн дэмжиж, эдийн засгийн өсөлтийг хадгалахуйц менежмент шаардлагатай болох нь харагдаж байна. Түүнчлэн эдийн засгаа либералчлах чиглэлд тодорхой ахиц гаргаж чадвал бүс нутгийн глобалчлалын үйл явцад татагдан орох нэг алхам болно. ЗХА-ийн орнуудын 2002 оны хөгжлийн төлөв байдлыг тоймлон өгүүлэхэд ийм дүр зураг харагдаж байна.

Одоо бид бүс нутгийн орнууд маань глобалчлалын шинэ эриний хөгжлийн үндсэн үзэл баримтлал, түүнийг залан чиглүүлэгч гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөд буй шинэ сонгодог либерализмын амин сүнс нь болсон эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүд нь ямар байгааг авч үзье. Энэ үзүүлэлт нь бүс нутгийн орнууд аль хэр глобалчлагдаад байгааг тодорхой харуулдаг нэг ёсны барометр гэж хэлж болно. Дэлхийд нэрд гарсан судалгааны байгууллага болох АНУ-ын “Heritage Foundation” жил бүр дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индексийг судлан тогтоодог уламжлалтай. Уламжлал ёсоор 2003 онд гаргасан индексийг “The Wall Street” сэтгүүлд нийтэлжээ. Индексийн гол шалгуур үзүүлэлтээр тухайн орны худалдаа, санхүүгийн дарамт, эдийн засагт засгийн газрын оролцоо, мөнгөний бодлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт, банк, санхүүгийн бодлого, цалин хөлс, үнэ ханш, өмчийн эрх, төрийн зохицуулалт, далд зах зээл гэсэн арван үзүүлэлтийг гол шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна. Дээрхи үзүүлэлт 3,0-ээс доош байх юм бол тухайн орныг эдийн засаг нь бүрэн нээлттэй оронд тооцдог юм байна. ЗХА-ийн зургаан орны хувьд дэлхийн улсуудын дотор Япон 2,50 гэсэн ерөнхий оноогоор 35-р байранд, Өмнөд Солонгос 2,70 оноогоор 52-т, Монгол 3,00 оноогоор 72-т, Хятад 3,55 оноогоор 127-д, Орос 3,70 оноогоор 135-д, БНАСАУ 5,00 оноогоор 156-д буюу доороосоо нэгд оржээ. Дээрхи үзүүлэлтээс харахад Япон, Өмнөд Солонгосоос бусад орнуудад эдийн засгийн эрх чөлөө ямар нэгэн хэмжээгээр хязгаарлагдмал гэсэн судалгаа гарчээ. Өөрөөр хэлбэл глобалчлалын урсгалд нэгдэн нийлэх тал дээр улс орон бэлэн бус байна гэсэн үг. Иймд дээрхи орнууд эдийн засгаа улам бүр либералчилж нээлттэй болгох нь улс орны цаашдын хөгжлийн эрх ашигт нийцэх биз ээ. ЗХА-ийн орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индексийг дараах хүснэгтээс үзнэ үү.

### ЗХА-ийн орнуудын эдийн засгийн эрх чөлөөний индекс

Зэрэглэл	Улс	Ер. Оноо	Худалдаа	Санхүүгийн драмт	ЗГ-ын оролцоо	Мөнгөний бодлого	ГШХО	Банк санхүү	Цалин хөлс үнэ ханш	Өмчийн эрх	Зохицуулалт	Далд зах зээл
1.	Япон	2.50	2.0	4.0	3.0	1.0	3.0	3.0	2.0	2.0	3.0	2.0
2.	БНСУ	2.70	3.0	3.0	4.0	2.0	2.0	3.0	2.0	2.0	3.0	3.0
3.	Монгол	3.00	2.0	4.5	2.5	3.0	3.0	3.0	2.0	3.0	4.0	3.0
4.	Хятад	3.55	5.0	3.0	4.0	1.0	4.0	4.0	3.0	4.0	4.0	3.5
5.	Орос	3.70	4.0	3.5	2.5	5.0	3.0	4.0	3.0	4.0	4.0	4.0
6.	БНАСАУ	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0

Эх сурвалж: Хөгжлийн эдийн засгийн асуудлууд, 2003.№3

ЗХА-ийн орнууд маань бүс нутгийн интеграцлалд хэрхэн оролцож байгааг энд цөөн үгээр дурьдах нь зүйтэй мэт санагдана. Өнөөгийн байдлаар бүс нутгийн интеграцлалд хамгийн их ач холбогдол өгч байгаа орон бол Хятад. Хятад ЗХА-ийн эдийн засгийн интеграцийн үйл явцад голлон тоглогч болохыг хүсдэг. Энэ чиглэлд явуулж байгаа үйл ажиллагаа нь жилээс жилд улам бүр эрчимжиж сүүлийн жилүүдэд бүсийн орнууд дотроо давамгайлах байр суурьтай болж ирлээ. Үүнийг Япон, Өмнөд Солонгос хоёр зүгээр хараад суухыг хүсэхгүй байна. Тэд бүс нутагт өөрийн байр сууриа хэвээр хадгалах, нөлөөний хүрээгээ өргөтгөх үүднээс Хятадтай хамтарч бүс нутгийн хэмжээний хамтран тоглогч болох зорилт тавиад байна. Энэ үүднээс 1999 оноос эхлэн 3 орон өөр хоорондоо хийж буй худалдаа, хамтын ажиллагаагаа аль болох уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг харилцан хөхүүлэн дэмжих, гааль татварын нэгдсэн бодлого явуулах зэргээр асар хурдтай интеграцчлагдаж байна. Тэд хамтын ажиллагааныхаа энэ суурин дээр АСЕАН+3 гэсэн томёолол гаргаж Зүүн Азийн орнуудтай эн түрүүнд интеграцчлагдах бодлого барих болов. Энэ нь ЗХА-ийн интеграцийн суурь дэвсгэр болно гэж тэд үзэж байна. ЗХА-ийн интеграцийн үйл явцыг бусад бүс нутгийн интеграцтай харьцуулж үзвэл нэлээд удааширалтай байгаа. Орон бүр өөр өөрсдийн эрх ашгаа урьдал болгосон амбиштай, түүнээсээ зоригтой гарч чадахгүй байгаа болон эдийн засгийн бус улс төрийн шинж чанартай саад тотгор ч нөлөөлж байгаа юм. Жишээ нь Япон том гүрний хувьд дэлхийн, нийт Азийн хэмжээний бодлогодоо түлхүү анхаарал хандуулдаг, бүсийн орон тус бүртэй ямар нэг асуудалтай(Монголоос бусад), Оросын хувьд Европт илүү анхаарал хандуулдаг, янз бүрийн таагүй хүчин зүйлийн улмаас ЗХА-ийн орон тус бүртэй худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөтгөх

боломж зарим талаар хязгаарлагдмал зэрэг сөрөг хүчин зүйлийн улмаас энэ бүс нутгийн интеграцид голлон тоглогчын хэмжээнд хүрэхэд нэлээд зай байна. Хэрэв Орос улс нефть, байгалийн хий болон бусад эрдэс баялгийн ордыг хамтран ашиглах талаар эрчимтэй бодлого хэрэгжүүлж эхэлбэл бүс нутгийн интеграц богино хугацаанд эрч хүчээ авах асар их нөөц боломж бий. Үүнээс үзэхэд өнөөгийн байдлаар Хятад, Өмнөд Солонгос хоёр бүс нутгийн интеграцийн үйл явцад хамгийн идэвхитэй оролцогч, голлон тоглогчид болоод байна.

### ДУГНЭЛТ

Монгол Улсын хувьд бүс нутгийн интеграцийн үйл явцад идэвхитэй оролцох, глобалчлалын сорилтыг даван туулахад тулах түших орны нэг бол Өмнөд Солонгос гэж үзнэ. Учир нь Өмнөд Солонгос глобалчлалын эхний сорилтод өртөж туршлага сургамж авсан орон. Нөгөө талаар хоёр орны ард түмнүүдийн хооронд бий болсон найрсаг харилцаа, түүнчлэн хоёр орны хувийн хэвшлийн хамтын ажиллагаа илүү хурдтай хөгжиж энэ чиглэлд харилцан шууд хөрөнгө оруулалт (Монголын хөрөнгө оруулалттай 40 аж ахуйн нэгж Өмнөд Солонгост үйл ажиллагаа явуулж байна гэсэн мэдээ бий) өсөн нэмэгдсээр байгаа, нэн ялангуяа хувийн хэвшлийн хүрээнд Өмнөд Солонгосын мэдээлэл холбооны салбарын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа өргөжин тэлж байгаа зэрэг хангалттай олон хүчин зүйлүүдийг энд дурьдаж болох юм. Шинэ эриний хөгжлийн гол тулгуур нь оюуны үйлдвэрлэл билээ. Бид юуны өмнө, эхний ээлжинд цаг алдахгүйгээр солонгосчуудтай хамтарч шинээр бий болж буй өндөр технологийн үйлдвэрлэлийг Монголд бий болгох чиглэлээр тодорхой зорилт дэвшүүлэн тавих цаг болжээ. Энэ юу байж болох вэ гэвэл Орос, Хятадтай бус давын өмнө Өмнөд Солонгосын бизнесменүүдэд нэн таатай нөхцөл олгосон эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах явдал юм. Монгол Улс глобалчлалын үйл явцаас хоцрохгүй түүнд идэвхитэй оролцоно гэвэл бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Өмнөд Солонгостой тогтоосон эдийн засаг, худалдааны өнөөгийн таатай хөрс суурин дээр түүнийг бүх талаар өргөтгөн хөгжүүлэх асуудлыг төр засгийн эдийн засгийн гадаад бодлогын нэгэн чухал чиглэл болгон авч үзэх хэрэгтэй байна. Өнөөдөр манай залуу үеийнхэнд Солонгосын соёлын (Хан рю) урсгал хүчтэй түрэн орж ирж буйг ч бид анхаарах ёстой болов уу. Дээрхи нааштай хүчин зүйлүүдэд үндэслэн шинэ технологийг шилжүүлэн авч ашиглах, угсрах чиглэлээр



үйлдвэрлэл, худалдааны чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг хугацаа алдалгүй тавьж өгөх цаг болжээ. Шинэ технологийн чиглэлээр байгуулах энэ чөлөөт бүс байж болох хамгийн тохиромжтой нутаг бол Дорнод бүс нутаг юм. Дорнодын бүс нутаг дэд бүтэц сайн хөгжсөн, бүс нутгийн хамтын ажиллагааны түшиц газрын нэг. Тэнд шинэ технологийн парк байгуулах эхлэлийг зөв тавьж өгвөл ойрын ирээдүйд Америкийн шинэ технологийн үйлдвэрлэлийн бүс нутаг болсон Калифорнийн Сликаны хөндий шиг Монголын Сликаны хөндий тэнд сүндэрлэнэ гэдэгт эргэлзэх зүйлгүй. Тэгж чадвал Монголын маань хөгжлийн тулах нэгэн цэг тэр болно.

#### **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:**

1. "ERINA REPORT" June, 2003, Vol. 52
2. "The Wall Street" Journal 2003, №10
3. "Хөгжлийн эдийн засаг" сэтгүүл, 2003, №8
4. Eng Chuan Ong. "Anchor East Asian Free Trade in ASEAN", "The Wasington Quarterly" Spring 2003
5. Kim Mi-Hui, "Hub of North East Asia-New Visin" Korea Now, December, 2002.
6. Joint Report of The ASEAN-Japan Closer Economic Partnership Expert Group, September, 2002. Institute for International Economics, "New East Asian Blocs Could Alter Global Trading System", Washington, D.C., May 25, 2002 (press release)
7. Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл, Улаанбаатар 2003
8. Гадаад Худалдааны Гаалийн Статистик Мэдээлэл 2003, №10
9. IMIDAS, 2002, Шюүэйшя. 2002 он.
10. JAPAN. 2002. Keizai Koho Center., 2001.